



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 06 сарын 24 өдөр

Дугаар 1/25

Улаанбаатар хот

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн
бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай

Монгол улсын Эрүүл Мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1 дэх заалт, Нийслэлийн Онцгой комиссын даргын 2024 оны 06 дугаар хурлын шийдвэр, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/747 дугаар захирамж, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2024 оны А/90 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь :

1. 2024 оны 06 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн үргэлжлэн орсон борооны улмаас усны түвшин нэмэгдэж, үерийн нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан 2024 оны 06 дугаар сараас байгууллагын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

2. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан үер уснаас урьдчилан сэргийлэх, шаардлагатай багаж тоног төхөөрөмжөөр ханган бэлэн байдлыг хангах, эрсдлээс сэргийлж ажиллаж байгаа ажилчдыг илүү цагийн цалинг тооцож бодож олгох, ажил үүргийг чанартай гүйцэтгэх, удирдлага, мэргэжил арга зүйгээр хангах зохион байгууллатыг хийж ажиллахыг Хүний нөөц, дотоод хяналтын ажилтан (Г.Гантуяа)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хүний нөөц, дотоод хяналтын ажилтан (Г.Гантуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Х.ГАНБАТ